

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/65/-НА-СТА-ТШЗ  
ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: [byambasurend@audit.gov.mn](mailto:byambasurend@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## **Агуулга**

---

<u>1. Аудитын санал дүгнэлт</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл</u> .....	4-8
<u>3. Аудитын тайлан</u> .....	9
<u>3.1 Ерөнхий зүйл</u> .....	9
<u>3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт</u> .....	9
<u>3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал</u> .....	10
<u>3.4 Материаллаг байдал</u> .....	10
<u>3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга</u> .....	11
<u>3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв</u> .....	12
<u>3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг</u> .....	12
<u>3.8 Аудитын гол асуудал</u> .....	13
<u>3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</u> .....	13
<u>3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</u> .....	13
<u>3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал</u> .....	14
<u>4. Аудитын илрүүлэлт</u> .....	14
<u>5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл</u> .....	15

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/103  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

**Зөрчилгүй дүгнэлт**

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Б.ОТГОНХИШИГТ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ  
19020351

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>61,246,765.09</b>	<b>57,004,135.09</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>653,100.00</b>	<b>576,500.00</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>653,100.00</b>	<b>576,500.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	276,600.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	376,500.00	576,500.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>60,593,665.09</b>	<b>56,427,635.09</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>00.00</b>	<b>352,500.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	00.00	352,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>60,593,665.09</b>	<b>56,075,135.09</b>
35410	Бичиг хэргийн материал	2,920,970.00	2,321,240.00
35420	Аж ахуйн материал	15,539,982.72	15,539,982.72
35440	Түлш, шатах тослох материал	00.15	00.15
35470	Бусад хангамжийн материал	42,132,712.22	38,213,912.22
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,126,997,541.58</b>	<b>3,113,774,778.60</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,126,997,541.58</b>	<b>3,113,774,778.60</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,961,699,255.98</b>	<b>2,950,486,350.16</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,031,039,261.39	3,077,770,013.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	-300,433,036.48	-366,623,908.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	200,308,855.00	183,008,855.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-109,708,843.21	-117,265,564.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	73,354,516.02	74,539,516.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	-46,723,013.32	-37,342,583.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,524,217.50	90,704,217.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-40,145,784.78	-41,420,134.39
39209	Зам, гүүрийн байгууламж	2,000,000.00	2,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-1,665,683.68	-1,920,050.00
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	23,986.00	23,986.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	149,936,382.00	180,896,382.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-81,811,600.46	-93,884,378.84
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>165,298,285.60</b>	<b>163,288,428.44</b>
39301	Програм хангамж	1,713,000.00	1,713,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,111,000.00	-1,338,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	176,582,000.00	176,582,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-11,885,714.40	-13,668,571.56
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,188,244,306.67</b>	<b>3,170,778,913.69</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>77,018.39</b>	<b>2,970,047.80</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>77,018.39</b>	<b>2,970,047.80</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>77,018.39</b>	<b>2,970,047.80</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	77,018.39	2,685,247.80
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>00.00</b>	<b>284,800.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	284,800.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,188,167,288.28</b>	<b>3,167,808,865.89</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,188,167,288.28</b>	<b>3,167,808,865.89</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	627,926,463.77	627,926,463.77
51101	Өмч: - төрийн	627,926,463.77	627,926,463.77
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,278,759,825.72</b>	<b>2,258,401,403.33</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,278,759,825.72	1,278,759,825.72
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	979,641,577.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	281,480,998.79	281,480,998.79
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,188,244,306.67</b>	<b>3,170,778,913.69</b>

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>481,224,231.66</b>	<b>1,521,613,017.66</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>13,222,200.00</b>	<b>1,090,103,552.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,222,200.00	1,087,716,752.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,222,200.00	1,087,716,752.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	7,000,000.00	1,087,716,752.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	6,222,200.00	2,386,800.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>00.00</b>	<b>2,386,800.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	2,386,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>468,002,031.66</b>	<b>423,391,365.66</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>40,844,431.66</b>	<b>46,978,465.66</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	4,065,000.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн	00.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн	40,844,431.66	13,676,623.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт	00.00	12,227,900.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	16,008,942.66
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>427,157,600.00</b>	<b>384,531,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	427,157,600.00	384,531,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>590,243,876.40</b>	<b>584,531,543.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>590,243,876.40</b>	<b>584,531,543.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>554,350,689.16</b>	<b>534,314,339.85</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>245,662,778.05</b>	<b>229,153,441.90</b>
210101	Үндсэн цалин	171,642,474.45	149,731,404.32
210102	Нэмэгдэл	40,426,304.07	53,237,542.45
210105	Гэрээт ажлын хөлс	33,593,999.53	26,184,495.13
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>32,742,663.76</b>	<b>30,463,983.34</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,892,682.12	21,432,566.51
210202	Тэтгэмжийн даатгал	2,516,527.60	2,379,151.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,993,900.88	1,856,280.92
210204	Ажилгүйдлийн даатгал	485,411.14	429,467.94
210205	Эрүүл мэндийн даатгал	4,854,142.02	4,366,516.78
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>36,494,812.00</b>	<b>41,795,473.80</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,785,352.00	8,628,121.00
210302	Тулш, халаалт	31,287,120.00	30,454,752.80
210303	Цэвэр, бохир ус	1,422,340.00	2,712,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,207,465.00</b>	<b>23,041,185.00</b>
210401	Бичиг хэрэг	4,000,020.00	3,327,230.00
210402	Тээвэр, шатахуун	21,068,045.00	18,123,805.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,167,400.00	1,226,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	364,150.00
210408	Бараа материал акталсны зардал	972,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,573,498.00</b>	<b>1,050,000.00</b>
210604	Урсгал засвар	1,573,498.00	1,050,000.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>2,977,000.00</b>	<b>2,456,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,977,000.00	2,456,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,458,381.00</b>	<b>2,326,029.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,051,629.00	1,319,879.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	363,152.00	141,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	259,200.00	250,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	10,000.00
210807	Газрын төлбөр	47,600.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>196,234,091.35</b>	<b>204,028,228.81</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	73,020,690.00	78,033,608.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	156,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	123,213,401.35	125,838,618.81
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>35,893,187.24</b>	<b>50,217,204.03</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>185,000.00</b>	<b>00.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	185,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>35,708,187.24</b>	<b>50,217,204.03</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,708,187.24	50,217,204.03
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-109,019,644.74</b>	<b>937,081,473.78</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>26,230,400.00</b>	<b>59,379,221.02</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	26,230,400.00	59,379,221.02
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>73,522,031.51</b>	<b>16,819,117.19</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	73,522,031.51	16,819,117.19
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-47,291,631.51</b>	<b>42,560,103.83</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-156,311,276.25</b>	<b>979,641,577.61</b>

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>627,926,463.77</b>	<b>505,611,030.96</b>	<b>1,210,941,069.80</b>		<b>2,344,478,564.53</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	224,130,032.17		224,130,032.17
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>627,926,463.77</b>	<b>505,611,030.96</b>	<b>1,435,071,101.97</b>		<b>2,568,608,596.70</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0	-224,130,032.17	0		-224,130,032.17
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-156,311,276.25		-156,311,276.25
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>627,926,463.77</b>	<b>281,480,998.79</b>	<b>1,278,759,825.72</b>	<b>00.00</b>	<b>2,188,167,288.28</b>
D01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>627,926,463.77</b>	<b>281,480,998.79</b>	<b>1,278,759,825.72</b>	<b>00.00</b>	<b>2,188,167,288.28</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>627,926,463.77</b>	<b>281,480,998.79</b>	<b>1,278,759,825.72</b>	<b>00.00</b>	<b>2,188,167,288.28</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	979,641,577.61	00.00	979,641,577.61
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>627,926,463.77</b>	<b>281,480,998.79</b>	<b>2,258,401,403.33</b>	<b>00.00</b>	<b>3,167,808,865.89</b>

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>490,397,931.66</b>	<b>451,586,065.66</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>490,397,931.66</b>	<b>451,586,065.66</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>63,240,331.66</b>	<b>67,055,065.66</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	4,065,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	63,240,331.66	33,753,223.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	12,227,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>427,157,600.00</b>	<b>384,531,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	427,157,600.00	384,531,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>477,035,931.66</b>	<b>450,326,065.66</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>477,035,931.66</b>	<b>450,326,065.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>440,372,744.42</b>	<b>400,108,861.63</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>243,546,298.05</b>	<b>226,441,640.96</b>
210101	Үндсэн цалин	169,525,994.45	147,780,900.67
210102	Нэмэгдэл	40,426,304.07	52,424,144.11
210105	Гэрээт ажлын хөлс	33,593,999.53	26,236,596.18
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,829,248.37</b>	<b>30,567,554.87</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,875,077.65	21,427,236.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,304,845.06	2,382,512.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,659,182.39	1,884,424.73
210204	Ажилгүйдлийн даатгал	464,431.76	436,503.89
210205	Эрүүл мэндийн даатгал	4,525,711.51	4,436,876.32
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>36,744,812.00</b>	<b>41,795,473.80</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,785,352.00	8,628,121.00
210302	Түлш, халаалт	31,537,120.00	30,454,752.80
210303	Цэвэр, бохир ус	1,422,340.00	2,712,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,615,435.00</b>	<b>20,336,968.00</b>
210401	Бичиг хэрэг	4,344,970.00	2,727,498.00
210402	Тээвэр, шатахуун	20,103,065.00	15,648,820.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,167,400.00	1,226,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	734,650.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,500,000.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>2,977,000.00</b>	<b>2,456,000.00</b>
210702	Дотоод албан томиллолт	2,977,000.00	2,456,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,249,181.00</b>	<b>6,479,229.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,890,029.00	5,757,879.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	404,352.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	250,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	87,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>86,410,770.00</b>	<b>70,531,995.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,410,770.00	70,375,995.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	156,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>36,663,187.24</b>	<b>50,217,204.03</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>955,000.00</b>	<b>00.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	955,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>35,708,187.24</b>	<b>50,217,204.03</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,708,187.24	50,217,204.03
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>13,362,000.00</b>	<b>1,260,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>13,362,000.00</b>	<b>1,260,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>13,362,000.00</b>	<b>1,260,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>13,362,000.00</b>	<b>1,260,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,362,000.00	1,260,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-13,362,000.00</b>	<b>-1,260,000.00</b>

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>427,157,600.00</b>	<b>407,458,355.42</b>	<b>384,531,000.00</b>	<b>350,413,287.63</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>427,157,600.00</b>	<b>407,458,355.42</b>	<b>384,531,000.00</b>	<b>350,413,287.63</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>426,157,600.00</b>	<b>406,503,355.42</b>	<b>384,531,000.00</b>	<b>350,413,287.63</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>243,546,300.00</b>	<b>243,546,298.05</b>	<b>243,546,300.00</b>	<b>226,441,640.96</b>
210101	Үндсэн цалин	172,208,400.00	169,525,994.45	172,208,400.00	147,780,900.67
210102	Нэмэгдэл	37,743,900.00	40,426,304.07	37,743,900.00	52,424,144.11
210105	Гэрээт ажлын хөлс	33,594,000.00	33,593,999.53	33,594,000.00	26,236,596.18
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх үнэмлэхүй үлдэгдэл</b>	<b>32,878,800.00</b>	<b>29,829,248.37</b>	<b>32,878,800.00</b>	<b>30,567,554.87</b>
210201	Тэтгэврийн даатгал	23,136,900.00	20,875,077.65	23,136,900.00	21,427,236.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,435,400.00	2,304,845.06	2,435,400.00	2,382,512.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,948,400.00	1,659,182.39	1,948,400.00	1,884,424.73
210204	Ажилгүйдлийн даатгал	487,200.00	464,431.76	487,200.00	436,503.89
210205	Эрүүл мэндийн даатгал	4,870,900.00	4,525,711.51	4,870,900.00	4,436,876.32
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>48,632,400.00</b>	<b>36,744,812.00</b>	<b>49,632,400.00</b>	<b>41,795,473.80</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,806,600.00	3,785,352.00	5,806,600.00	8,628,121.00
210302	Түлш, халаалт	42,945,000.00	31,537,120.00	42,945,000.00	30,454,752.80
210303	Цэвэр, бохир ус	880,800.00	1,422,340.00	880,800.00	2,712,600.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,399,200.00</b>	<b>25,367,935.00</b>	<b>21,431,900.00</b>	<b>21,421,968.00</b>
210401	Бичиг хэрэг	4,100,800.00	4,097,470.00	2,552,500.00	2,552,498.00
210402	Тээвэр, шатахуун	20,108,400.00	20,103,065.00	15,679,400.00	15,648,820.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,190,000.00	1,167,400.00	1,200,000.00	1,226,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн ус	00.00	00.00	2,000,000.00	1,994,650.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	1,500,000.00	1,500,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,712,300.00</b>	<b>2,977,000.00</b>	<b>5,712,300.00</b>	<b>2,456,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,712,300.00	2,977,000.00	5,712,300.00	2,456,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,370,800.00</b>	<b>3,038,182.00</b>	<b>820,000.00</b>	<b>721,350.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	1,679,030.00	00.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00	320,000.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	416,000.00	404,352.00	150,000.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	250,000.00	250,000.00	250,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	100,000.00	100,000.00	87,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>64,617,800.00</b>	<b>63,999,880.00</b>	<b>29,009,300.00</b>	<b>25,509,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,617,800.00	63,999,880.00	29,009,300.00	25,509,300.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,000,000.00</b>	<b>955,000.00</b>	-	-
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,000,000.00</b>	<b>955,000.00</b>	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	955,000.00	-	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>427,157,600.00</b>	<b>427,157,600.00</b>	<b>384,531,000.00</b>	<b>384,531,000.00</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>427,157,600.00</b>	<b>427,157,600.00</b>	<b>384,531,000.00</b>	<b>384,531,000.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	427,157,600.00	427,157,600.00	384,531,000.00	384,531,000.00
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>01</b>	<b>01</b>	<b>01</b>	<b>01</b>
610001	Төсвийн байгууллага	01	01	01	01
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>25</b>	<b>25</b>	<b>25</b>	<b>25</b>
620001	Удирдах ажилтан	08	08	08	08
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15	15	15
620003	Үйлчлэх ажилтан	02	02	02	02

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>47,231,389.00</b>	<b>50,955,574.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>47,231,389.00</b>	<b>50,955,574.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>47,231,389.00</b>	<b>50,955,574.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>247,500.00</b>	<b>175,000.00</b>
210401	Бичиг хэрэг	247,500.00	175,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,210,999.00</b>	<b>5,757,879.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,210,999.00	5,757,879.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>35,772,890.00</b>	<b>45,022,695.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,772,890.00	44,866,695.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	156,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>48,884,878.85</b>	<b>67,055,065.66</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>48,884,878.85</b>	<b>67,055,065.66</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	4,065,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,884,878.85	33,753,223.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	28,236,842.66
131106	Төсвийн урамшуулал	-	-
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн гүйцэтгэл, өр, авлагатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 03/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газар нь оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилготой төрийн захиргааны байгууллага юм.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын ажлын хэсгийг 2019 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн А/02 тушаалаар шинэчлэн 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллажээ.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын баг Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан журмыг баримтлан Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулан ажилласан байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт дотоод аудитын албаны 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 33/07 тоот дотоод аудитын хорооны даргын баталсан удирдамжаар Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж, 6 зөвлөмж өгөгдөж “дунд” эрсдэлтэй гэж дүгнэсэн байна.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зарлагын 590,243.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 8,853.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,640.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас дахин тооцож үзэхэд гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 7,794.9 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 1,058.7 мянган төгрөгөөр буурсан тул материаллаг түвшинг дахин тооцох шаардлагагүй гэж үзэв.

Учир нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон нийт зарлага 590,243.9 мянган төгрөг гүйцэтгэлийн үе шатны зарлага 519,660.2 мянган төгрөг 70,573.7 мянган төгрөгөөр зардал буурсан байна.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Бүрэн сумын Засаг даргын Тамгын газарт мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

### **Орлого:**

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 384,531.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1,087,716.7 мянган төгрөг, нэмэлт санхүүжилт 46,978.5 мянган төгрөг, хандив тусламжаар 2,386.8 мянган төгрөг нийт 1,521,613.0 мянган төгрөг өмнөх оноос 1,040,388.9 мянган төгрөгөөр буюу 2.2 дахин нэмэгдсэн байна.

### **Зардал :**

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 584,531.5 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 450,326.1 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 350,413.3 мянган төгрөг зарцуулсан байна.

### **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:**

Тус байгууллага төрийн сангийн 100142855001 тоот дансанд 2021 онд 384,531.0 мянган төгрөгийн орлого, 384,531.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 100142855401 тоот дансанд 67,055.1 мянган төгрөгийн орлого, 67,055.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна.

### **Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган.төгрөг/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	653.1	576.5	-76.6
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	60,593.7	56,427.6	-4,166.1
Үндсэн хөрөнгө	2,126,997.5	3,113,774.8	986,777.3
Нийт хөрөнгө	2,188,244.3	3,170,778.9	982,534.6
Өр төлбөр	77.0	2,970.0	2,893.
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,188,167.3	3,167,808.9	979,641.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,188,244.3	3,170,778.9	982,534.6

Авлага дансны оны эхний үлдэгдэл 653.1 мянган төгрөгийг 76.6 мянган төгрөгөөр бууруулж, оны эцэст гарсан 576.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 56,427.6 мянган төгрөг болж 4,166.1 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын зарцуулалтаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,113,774.8 мянган төгрөг болж 986,777.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь үнэ төлбөргүй хүлээн авсан 1,087,716.8 мянган төгрөг, худалдаж авсан 2,440.0 мянган төгрөг, балансас балансд шилжүүлэн авсан 60,200.0 мянган төгрөг, дахин үнэлгээ хийсэн 33,278.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж акталж устгасан 116,879.2 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,167,808.9 мянган төгрөг болж 979,641.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 443,482.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 443,482.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 77,960.4 мянган төгрөгөөр бууруулж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас 357,403.6 мянган төгрөгөөр ирүүлсэн санал дээр сумын шилжих үлдэгдлээс 10,891.2 мянган төгрөг нэмж орон нутгийн төсвөөс 368,294.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр Бүрэн сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан байна. Бүрэн сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны 4 дүгээр тогтоолоор 384,531.0 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 384,531.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 384,531.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 384,531.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 350,413.3 мянган төгрөгийг зарцуулж, 34,117.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 350,413.3 мянган төгрөг буюу 91.12 хувьтай байгаа нь 34,117.7 мянган төгрөг буцаан төвлөрүүлж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд хандиваар 4,065.0 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 1,000.0 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 33,753.2 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 12,227.9 мянган төгрөг нийт 67,055.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар бичиг хэргийн зардал 175.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 5,757.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 45,022.7 мянган төгрөг нийт 50,955.6 мянган төгрөг зарцуулж, 16,099.5 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2021 онд Мета менежмент ХХК-ийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар барьсан 955,455.8 мянган төгрөгийн Засаг даргын Тамгын газрын контор, 31,245.2 мянган төгрөгийн гүний худаг 3 ш, иргэнээс 5,185.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмж тус тус үнэ төлбөргүй, 60,200.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг шилжүүлэн авч, төсвийн хөрөнгөөр 2,440.0 мянган төгрөгийн эд хогшил худалдан авч данс бүртгэлд тусган тайлагнасан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд Ковидод 4,065.0 мянган төгрөгийг хандиваар хүлээн авсан байна. Тайланд онд шүлхий өвчний зардалд 4,266.3 мянган төгрөг зарцуулсан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 90 мэдээлэл, хугацаа хоцроосон 42 мэдээлэл байна. Тус байгууллага 5,0 саяас дээших

орлогын 23, зарлагын 3 гүйлгээ байршуулж, 5,0 саяас дээших худалдан авалтын 10 гүйлгээ байршуулсан байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар элэгдэл нь дууссан хөрөнгийг дахин үнэлж данс бүртгэлд тусгах 1 зөвлөмж, арвилан хэмнэлт, үр ашигтай холбоотой 1 төлбөрийн акт өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 03/297 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тус байгууллагад балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 1,010,815.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 986,730.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 20,211.9 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 3,873.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

### **4.2.1 Залруулсан алдаа**

Тус байгууллага тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр ашиглалтад Засаг даргын Тамгын газрын 955,485.6 мянган төгрөгийн конторын барилга, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр ашиглалтад орсон 31,245.2 мянган төгрөгийн 3 гүний худгийг данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

### **4.2.3 Албан шаардлага**

1. Тус байгууллага тайлант онд худалдан авалт бүрд е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар баталгаажсан эсэхийг тулган шалгахад 15,746.9 мянган төгрөгийн 14 байгууллагын гүйлгээ е баримтаар баталгаажгаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “Үнэлгээ”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2. Тус байгууллага тайлант онд Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.6 дах заалтыг зөрчин Худалдааны 100 жилийн ой тэмдэглэж медаль, энгэрийн тэмдгийн төлбөрт 2,025.0 мянган төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

3. Тус байгууллага тайлант онд Засгийн Газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг зөрчин эд хогшлын зардалд 2,440.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтуудыг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

#### 4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

#### ***Илрүүлэлт:***

1.Тус байгууллага тайлант онд Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.5 дах заалтыг зөрчин сургалт, семинар, хурал, зөвлөгөөний томилолтын зардалд 903.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтуудыг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах.

2. Тус байгууллага тайлант онд НДШ-ийн зардалд 2,648.1 мянган төгрөг, цалингийн зөрүү 37.2 мянган төгрөг, аудитын дутуу төлбөрт 284.8 мянган төгрөг нийт 2,970.0 мянган төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Өр, авлага шинээр үүсгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### **5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	ЗДТГ	6	1,010,815.7	1	986,730.8	0	0	3	20,211.9	2	3,873.0
	<b>Дүн</b>	<b>6</b>	<b>1,010,815.7</b>	<b>1</b>	<b>986,730.8</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>20,211.9</b>	<b>2</b>	<b>3,873.0</b>
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	ЗДТГ										

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>Дүн</b>										
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>1,010,815.7</b>	<b>1</b>	<b>986,730.8</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>20,211.9</b>	<b>2</b>	<b>3,873.0</b>